



**МОНГОЛЫН САГСАН  
БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ**

1016245, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо, Сүхбаатар талбай,  
Сэнтрал Тауэр 4 давхар, 407а  
Tel:(976)-88886579,(976)-77114144

2023 01.19 № 12  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“М-ГАРЬД” БАГТ

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Монголын Сагсан бөмбөгийн Холбоо НҮТББ /цаашид “Холбоо” гэх/-аас зохион байгуулж байгаа Үндэсний дээд лигийн 2022-2023 оны улирлын тэмцээний 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Эрдэнэтийн уурхайчин”- “М-Гарьд” багуудын тоглолтын үеэр танай багийн тоглогч болон багийн албаны хүмүүс Үндэсний дээд лигийн тэмцээн зохион байгуулах журам /цаашид “Лигийн тэмцээний журам” гэх/ болон Багуудтай байгуулсан хариуцлагыг гэрээг зөрчсөн үйлдэл гаргасан байна.

Тус багийн албаны эрх бүхий этгээд нь тоглолтын талбайруу усны сав шидэх, үзэгчид болон тэмцээн зохион байгуулагч албаны хүмүүстэй хүндэтгэлгүй харьцсан асуудал үүсгэсэн байх бөгөөд өмнө буюу 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагч албаны хүмүүстэй ёс зүйгүй харьцсан бусдын бие махбодид нь халдсан асуудалд мэдэгдэл хүргүүлсээр байхад зөрчлийг давтан гаргаж байх тул Лигийн тэмцээн зохион байгуулах журмын Хавсралтад заасан Зөрчлийн хэлбэрийн 2.6-д заасан зөрчлийн гаргаж хариуцлага хэсгийн 2-ийн хоёрт зааснаар багийг 850,000 /найман зуун тавин мянга/ төгрөгөөр торгох шийтгэлийг ногдуулж байна. Энэхүү торгуулийг Лигийн тэмцээний журмын 5.10-т заасан заасан журмаар төлж биелүүлэхийг мэдэгдэж байна.

Харин дээр дурдсан 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Эрдэнэтийн уурхайчин” - “М-Гарьд” багуудын тоглолтын 4-р үеийн 06:28 минутын үед “М-Гарьд” багийн тоглогч Б.Мөнхболдын “Эрдэнэтийн Уурхайчид” багийн тоглогч Г.Ган-Эрдэнэтэй бөмбөг булаалдах үед гаргасан алдааны улмаас 2 багийн тоглогчид маргаан гаргаж, энэ үйлдэлд бухимдсан зарим үзэгчидээс тоглолтын талбайд усны сав шидэж, үзэгчидтэй тоглогчид маргалдан, эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй зохисгүй явдал гарсан. Тоглолтын үед гаргасан тоглогчдын алдаанд талбайн шүүгчид дүрмийн дагуу шийдвэрийг гаргаж хариуцлага хүлээлгэсэн.

Дээрх үйлдэл нь тоглогчдийн хувийн сахилга, ёс зүйн зөрчил байсан бөгөөд Лигийн Мэргэжлийн зөвлөл болон Ажлын хэсгийг нэгтгэсэн хуралдаанаар Лигийн тэмцээний журам болон Багуудтай байгуулсан хариуцлагыг гэрээг үндэслэн доорхи зөрчлийг ногдуулан шийдвэрлэснийг үүгээр мэдэгдэж байна. Үүнд:

1. “М-Гарьд” багийн тоглогч Б.Мөнхболд нь тоглолтын явцад гарсан контактын улмаас эсрэг багийн тоглогч Г.Ган-Эрдэнийг түлхэж, талбайгаас гаргахдаа биед нь халдсан үйлдэл үзүүлсэн байдлыг эсрэг багийн тоглогч Г.Ган-Эрдэнэ бухимдаж, хариу үйлдэл үзүүлсэн нь маргаан гарах нөхцөлийг бүрдүүлсэн. Хоёр багийн тоглогчдын гаргасан маргааныг шүүгчид бичлэг үзэж шийдвэр гаргах хооронд “М-Гарьд” багийн тоглогч Б.Мөнхболд нь өөрийн багийн бүсэд байлгүйгээр эсрэг багийн бүсэд очиж тамирчид болон туслах дасгалжуулагчидтай маргалдах, өдөөн хатгасан шинжтэй үйлдэл гаргасан нь үзэгчдийг турхирсан үйлдэл болсон. Энэ нь тэмцээний журмын 5.1-т “Лигийн тэмцээнд оролцож байгаа багийн эзэд, менежер, дасгалжуулагч, тоглогч, шүүгч, багийн албаны хүмүүс, Ажлын хэсэг нь сагсан бөмбөгийн спортыг хүндэтгэн, олон нийтийн дунд лигийн тэмцээн, баг, тамирчдын нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн холбооны дүрэм, энэхүү журмыг баримтлах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг зөрчсөн үйлдэлд хамаарч байна. Лигийн тэмцээний журмын Хавсралтад заасан Зөрчлийн хэлбэрийн 1.1 болон 1.5-д заасан зөрчлийг гаргасан бөгөөд хариуцлага хэсгийн 2-ийн хоёрт зааснаар 1 /нэг/ тоглолт өнжүүлэх шийтгэл оногдуулсан;